ДАМЖИН ӨНГӨРӨХ ЖУРМЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" хэмээх/,

Хэлэлцэн тохирогч Талуудын төрийн ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг удирдлага болгон,

хоёр талын хооронд тогтсон найрамдалт харилцааг иш үндэс болгон,

улсуудын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх хөдөлгөөн хийх, түүнийг хөгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч,

олон улсын эрх зүйн зарчимд үнэнчээ нотолж, дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн доорх нэр томъёо дараах утгыг илэрхийлэв:

а/"Гуравдагч орон" гэж энэхүү Хэлэлцээрт оролцоогүй орныг хэлнэ;

б/"Дамжин өнгөрөх хөдөлгөөн" гэж Хэлэлцэн тохирогч нэг талын хүмүүс, тээврийн хэрэгсэл, тээш, ачааг түүнчлэн бараа, улс хоорондын шууданг шилжүүлэн ачих, хадгалах, хэсэглэх, бүлэглэх юмуу тээврийн хэрэгслийг солих, эсвэл эдгээр үйлдлийг хийхгүйгээр, дамжин өнгөрөх орны нутаг дэвсгэрийн гадна эхлэх ба дуусах замын энэ хэсэгт дамжуулан өнгөрүүлэх үйл ажиллагааг хэлнэ;

в/"Дамжин өнгөрөх улс" гэж нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрөх хөдөлгөөн дайрч гарах улсыг хэлнэ;

г/"Тээврийн хэрэгсэл" гэж төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, авто тээврийн хэрэгсэл, далайн ба гол мөрний хөлөг

Бүртгэлийн дугаар 160
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар үйлдсэн ажилтан
05
14 3 4

онгоц, нефть болон хий дамжуулах хоолой, тэрчлэн бусад төрлийн тээврийн хэрэгслийг хэлнэ.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нь энэхүү Хэлэлцээрийн дагуу өөрсдийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хөдөлгөөнийг чөлөөтэй явуулах эрхийг бие биендээ олгоно.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нь дамжин өнгөрөх хөдөлгөөнийг хангахтай холбогдуулж үзүүлэх тодорхой үйлчилгээнд авах хураамжаас өөр гаалийн болон бусад татвар хураамжийг дамжин өнгөрөх хөдөлгөөнд ногдуулахгүй.

Дөрөвдүгээр зүйл

I.Гуравдагч оронд тээвэрлэж байгаа, явуулагч улсын гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй ачааг Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлж гуравдагч оронд гаргахыг зөвшөөрөхгүй.Тийм ачааг дамжин өнгөрүүлэх улсын нутагт саатуулж, гаалийн бүрдүүлэлт хийлгэхээр илгээсэн улсад нь буцаана.

Дамжин өнгөрөх ачааг саатуулсантай холбогдож гарах бүх зардлыг илгээгч хариуцна.

2.Дамжин өнгөрүүлэх улсын нутгаар ачааг явуулахдаа олон улсын тээврийн дүрмийн дагуу зохицуулна.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь оруулж, гаргах болон өөрсдийн нутгаар дамжуулахыг хориглосон ачааны жагсаалтыг гаргаж бие биендээ өгнө.

Бүртгэлийн дугаар 160
МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар хийсэн ажилтан
01
14 3 4

Зургадугаар зүйл

1.Дамжин өнгөрөх хөдөлгөөнийг хангахтай холбогдон гарах тээвэр үйлчилгээний ажлыг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагын тогтоосон үйлдвэр, байгууллагууд нутаг дэвсгэртээ гүйцэтгэнэ.

2.Дурдсан ажлыг гүйцэтгэхэд гарах зардлыг тооцох зорилгоор Хэлэлцэн тохирогч Тал тус бүрийн нутаг дэвсгэртээ хэрэглэх тариф, хураамжийн хэмжээ нь Хэлэлцэн тохирогч Талуудын оролцдог олон улсын Хэлэлцээрээр тогтоосон тариф, хураамжийн түвшингээс өндөр байх ёсгүй.

Долдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрээс үүдэн гарах төлбөрийг Засгийн газар хоорондын худалдаа-төлбөрийн хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрээр дайрч өнгөрөх хөдөлгөөний хувьд гаалийн бүрдүүлэлтийг аль болохоор хөнгөвчилнө.

Дамжин өнгөрөх улсын дотоодын хууль тогтоомжоор хориглосон зүйлийг тээвэрлэж байна гэх ноцтой үндэслэлгүй бол Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд дамжин өнгөрөх ачаа тээшийг шалгахгүй.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нь Олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээний дагуу далайд гарцгүй орны газар зүйн онцгой байршлыг харгалзан тогтоосон эрх, хөнгөлөлтийг бие биедээ олгоно.

Хуудасны дугаар 160
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
05
14 3 4

Аравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн заалтыг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.

Арван нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн заалтанд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцож бичгээр үйлдэнэ.

Арван хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт дурдсан эрх бүхий байгууллага нь:

Монголын Талаас:

6,I0,II дүгээр зүйлээр -Зам, тээвэр, холбооны Яам

5, 8 дугаар зүйлээр -Улсын Гаалийн ерөнхий газар

Казахстаны Талаас:

6, I0, II дүгээр зүйлээр -Бүгд Найрамдах Казахстан Улсын Тээврийн яам.

5, 8 дугаар зүйлээр -Бүгд Найрамдах Казахстан Улсын Сангийн Яамны Гаалийн ерөнхий газар.

Арван гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Бүртгэлийн дугаар 160
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар хийсэн ажилтан
Оғ
14 3 4

Арван дөрөвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийг 10 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 12 сарын өмнө түүнийг цуцлах тухай саналаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд бичгээр мэдэгдээгүй бол Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа нь дараа дараачийн таван жил тутамд аяндаа сунгагдана.

Энэхүү Хэлэлцээрийг 1993 оны 10 дугаар сарын "22"-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, казах хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

Бүртгэлийн дугаар 160
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар хийсэн ажилтан
(албан тушаал, гарын үсэг, гарын үсгийн тайлал)
2014 оны 3 сарын 4 ний өдөр